



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/121

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Нийгэмд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, гэр бүлийн үнэт зүйл, боловсролыг дээшлүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 03 дугаар сарыг "Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сар", 04 дүгээр сарыг "Хүүхэд хамгааллын сар", 05 дугаар сарыг "Гэр бүлийн үнэт зүйл, эрчүүдийн манлайллын сар" болгон тус тус зарласугай.

2.Дээрх аяны хүрээнд төлөвлөгөөт ажлыг зохион байгуулах, салбар хоорондын уялдаа холбоог хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


3.Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу арга хэмжээг чанартай зохион байгуулж, үр дүнг нэгтгэн тухай бүр танилцуулахыг ажлын хэсэг (Э.Энхнаран), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 05-ны өдрийн 41 дүгээр
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Э.Энхнаран	(Аймгийн Засаг даргын Нийгмийн салбарын төслийн удирдагч)
Гишүүд:	Ж.Амгаланбаатар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
	Я.Жаргалцэцэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
	Д.Буянхишиг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)
	М.Туул	(Аймаг дахь төрийн албаны салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга)
	О.Баатарчулуун	(Эрүүл мэндийн газрын дарга/
	Ж.Уранчимэг	Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга)
	Д.Энхцэцэг	(Боловсролын газрын дарга)
	С.Цагаанбаатар	(Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)
	Д.Баттайван	(Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга)
	Х.Ундармаа	(Насан туршийн суралцахуйн төвийн захирал)
	Б.Оюунцэцэг	(Цахим шилжилт, үйлчилгээний хэлтсийн дарга)
	Т.Сүхбаатар	("Алтай усан спорт, чийрэгжүүлэлтийн газрын дарга)
	Ж.Батцэцэг	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
	Л.Ариунтуяа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Б.Цэнд-Аюуш	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ ЖДҮ-ийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
Б.Мөнхжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол шинжлэх ухаан, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн)	
Нарийн бичгийн дарга:	Б.Алтайбаатар	(Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга)

